

Sika® Fibre MN

Бетон болон зуурмагын полипропилен фибер

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® Fibre MN нь сайн чанарын бичил полипропилен суурьтай фибер юм. Энэ нь шингэн бетоны ачаалал даах чадварыг нэмэлгдүүлсэнээр хялгасан ан цавыг бууруулан, хянах зориулалттай бүтээгдсэн юм.

Sika® Fibre MN нь 1м³ бетонд хийх зориулалттай хайлдаг уутанд савлагдан бэлэн бүтээгдэхүүн болно.

Хэрэглээ:

Sika® Fibre MN-ийг шингэн бетонд хийж хялгасан ан цавыг бууруулан дараах бүтээцэд ашиглах боломжтой:

- Засмал зам
 - Бэлэн хийц эдлэлд
 - Үйлдвэрийн зориулалттай шал, хавтанд
 - Шингэн болон хуурай шүршдэг бетон үйлдвэрлэлд
 - Онгоцны буудлын автомашины зогсоолын хавтанд
 - Өндөр ачаалал бүхий бетон эдлэл
 - Өнгөлгөө, тэгшилгээний шавардлага г.м
-

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

Sika® Fibre MN -ийн нарийн ширхэглэг болон гадаргуун боловсруулалтын үр дүнд бүх төрлийн бетон болон шаварт хялбархан холилдож нягт шигүү бүтэц бий болгосноор дараах давуу талыг үүсгэнэ:

- Шингэн бетоны төлөвийг нягтруулна
 - Агшилтаас үүдэлтэй хялгасан ан цавыг бууруулна
 - Бетон зуурмагын ялгаралтын бууруулна
 - Элэгдэлд тэсвэртэй бүтэцтэй болно
 - Хөлдөлт, гэсэлтэд тэсвэртэй болно
 - Шүршдэг бетонд хэрэглэхэд барьцалдахгүй ойж уналтын хэмжээ буурна
 - Ачаалал даах чадвар нэмэгдэнэ
 - Бетоны нэвчилтыг бууруулна
 - Галаас үүдэх эвдрэлийг бууруулна
-

Construction

Бүтээгдэхүүний үзүүлэлт

Хэлбэр

Өнгө / хэлбэр	Цагаан
Сав баглаа боодол	1кг-ийн уусдаг ууттай (хайрцагандаа 20 уут)

Хадгалалт

Хадгалах хугацаа	Хуурай, сэрүүн, цэвэр орчинд сав баглааг онгойлгоогүй, бүрэн бүтэн байгаа тохиолдолд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 3 жил (36 сар) хүртэл хадглах боломжтой.
------------------	---

Техникийн үзүүлэлт

Химийн суурь	100% полипропилен фибер
Нягтын харьцаа	0,91 гр/см ³
Файберын урт	12 мм
Файберын диаметр	18 микрон
Шингээлт	0,
Хайлах цэг	160°C
Шатах цэг	365°C
Цахилгаан дамжуулалт	Бага
Дулаан дамжуулалт	Бага
Файберын гадаргуун хэмжээ	250 м ² /кг
Хүчил болон давсанд Тэсвэртэй байдал	Өндөр
Шүлтэнд тэсвэртэй байдал	100%
Гулзайлтын бат бэх	300 – 400 N/mm ²
E-модуль	~ 4,000 N/mm ²

Системийн мэдээлэл

Зарцуулалт	1 уут (1 кг) фибер нь 1 м ³ бетон зуурмагт хэрэглэгдэнэ.
------------	---

Зохицол

Sika® Fibre MN нь Сика брендийн олон төрлийн бүтээгдэхүүнтэй хослуулан хэрэглэх боломжтой бөгөөд жишээ нь:

- Sika® AER
- Sika Rapid
- Sika FerroGard® 901
- Sika Pump®

- Sika® Retarder®
- Sika® Antisol®
- ViscoCrete® төрлийн бүтээгдэхүүнүүд

Бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө заавал урьдчилсан туршилт хийж үзэх хэрэгтэй.

Хэрэглээний нөхцлүүд

Холих

Sika® Fibre MN-ийг зуурмагын үйлдвэрт хийх нь хамгийн тохиромжтой арга юм. Хэрэв барилгын талбай дээр зуурмаганд хийж холих шаардлага гарвал, фибераа зуурмагт хийгээд 3-5 минутын турш (70 эргэлт) сайтар хольж жигд тарсан эсэхийг шалгах хэрэгтэй. Хэрэв фиберыг зуурмагын үйлдвэрт хийж холих бол фиберыг хамгийн түрүүнд, орцын усны эхний тал хэсэгтэй хольж хийх шаардлагатай. Бетон болон зуурмагын бусад орц болон усны орцын үлдсэн тал хэсгийг хийсэний дараа 3 минутын турш сайтар хольж, фибер жигд тарж зуурмаг нэгэн жигд болсон эсэхийг шалгах хэрэгтэй.

Хэрэглэх аргачлал / Багаж

Sika® Fibre MN-тэй бетон зуурмагыг хэрэглэхдээ бетон үйлдвэрлэх, тээвэрлэх, цугтах, арчлах үеийн зөв практик ажиллагааг ханган ажиллах хэрэгтэй. Шингэн бетонд арчилгааг сайн хийж өгөх шаардлагатай.

Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө усаар сайтар цэвэрлэх хэрэгтэй. Бэхжиж хатсан бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Анхаарах зүйлс

Энэхүү Техникийн зааварчилгаанд лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэдээлэл

Аюулгүй ажиллагаа

- Ховор тохиолдох арьсны цочролоос урьдчилан сэргийлж хувийн хамгаалах хэрэгсэл болон бээлийн өмсөхийг зөвлөж байна. Ажлын засварлагаан болон ажил дууссаны дараа бохир хувцасаа сольж гараа гараа сайтар угаах хэрэгтэй.
- Тухайн орон нутгийн болон бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр заасан тусгагдсан Эрүүл, Аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжүүдийг хангаж ажиллах хэрэгтэй.
- Шаардлагатай тохиолдолд Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн зааварчилгааг биднээс авах боломжтой.
- Ямар нэгэн эргэлзэх зүйл гарвал бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр тусгагдсан зөвлөмжийн дагуу хэрэглэх нь зүйтэй.

Чухал санамжууд

Sika® Fibre MN нь төмөр арматурыг бууруулах зориулалттай бүтээгдэхүүн биш юм. Sika® Fibre MN нь бүтээцийн фибер биш учраас бүтээцийн эдлэлд бүтээцийн арматур, төмөр фиберыг орлуулан ашиглаж болохгүй. Ер нь бетоны фиберууд бетоны суултыг бууруулах нөлөө үзүүлдэг учир ViscoCrete® төрлийн уян налархайжуулагч хэрэглэхийг зөвлөж байна.

Бүтээгдэхүүний хаягдлыг тухайн орон нутгийн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хаягдал устгах цэг, талбайд устгана. Аюулгүй ажиллагаа, физик шинж чанарууд болон байгаль орчинтой холбоотой бусад мэдээллүүд Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Construction



Sika Mongolia LLC
Rm. 15, Building 21B,
1st Khoroo, Khan-Uul District,
Ulaanbaatar
MONGOLIA

Tel +976 7013 1360
Fax +976 7013 1360
website www.sika.com